



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 23 өдөр

Дугаар A/120

Баянхутаг сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.5, 4.1, 5.2, Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.5.3, Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 07 дугаарт хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Сумаас төрөн гарсан алдартнуудын амьдрал, гавьяа зүтгэлийг сурталчилсан бүтээлийг дэмжиж ажиллах тухай зорилтын хүрээнд Баянхутаг сумын харъяат Алдарт дууч Даншигийн аврага Мөррөнчингийн нэрэмжит уртын дууны улсын уралдаан зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан Хэнтий аймгийн ерөөлч, магтаалчдын холбоонд 1000000 /Нэг сая/ төгрөгний дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг Нягтлан бодогч /Г.Пүрэвдулам/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б. АМГАЛАНБАТ